

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд,
Дундговь аймгийн Засаг даргын 2017 оны
12 дугаар сарын 30-ны өдрийн
17/ДХ/ДХ-Хамтарсан тушаал, захирамжийн
нэгдүгээр хавсралт

**Дундговь аймгийн Мандалговь хотын агаарын чанарыг
сайжруулах бүсэд хамрагдах баг айл өрх, аж ахуйн нэгж, байгууллага**

Багууд	Багийн гудамж бүсийн ангилал		
	1 дүгээр бүс		
	Айл өрх /Гудамжаар/	Аж ахуйн нэгж, байгууллага	Төрийн болон орон нутгийн өмчийн байгууллага
8-р баг	Айраг 1- 11	-	-
9-р баг	Мандал 1-22	Баруун цагаан дэлгүүр	-
7-р баг	Нарлаг 1- 9	Ган-илч 1-7 зуух, Тэвшийн говь 1-2 зуух, Хөрх булаг ХХК, Цоглог ХХК, Сайнмандал ХХК, Ундрал ХХК, Номгон рашаан ХХК, Элбэг хайрхан ХХК, Өлзий-Дундговь ХХК, Сайн мандал ХХК, Алтанговь ХХК, Говийн тэнгэр ХХК, Алтан сант ХХК, Өнө мөнх хайрхан ХХК, Бөхт ХХК, Ялгуум ХХК, бусад	Нөөцийн төв, Тагнуулын хэлтэс, ИГЧБЦГХамгаалалтын захиргаа, Прокурорын газар, Улаан загалмай нийгэмлэг, Дундговь-УС ОНӨУГазар 1, 2 зуух, бусад

ХЯЗГААРЛАЛТЫН БҮС

Ногоон - 4-1-22

Улаан - Атираг - 4-11

Дундур - Карлаг - 4-9



Байгаль орчин, аялал жуулчлалын сайд,
Дундговь аймгийн Засаг даргын 2017 оны
28 дугаар сарын 30-ны өдрийн 1341/287
хамтарсан
тушаал, захирамжийн хоёрдугаар хавсралт

МАНДАЛГОВЬ ХОТЫН АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЯХ ХЯЗГААРЛАЛТЫН БҮСЭД МӨРДӨХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Мандалговь хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага агаарын чанарыг сайжруулах хязгаарлалтын бүсэд стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн хэрэглэх, түүхий нүүрсний хэрэглээг бууруулах дэглэмийг мөрдөх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журмыг Мандалговь хотын хязгаарлалтын бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллага, аж ахуйн нэгж байнга болон түр оршин сууж буй иргэн, харьяалалгүй хүн дагаж мөрдөнө.

1.3. Журмыг Мандалговь хотын Захирагчийн ажлын алба, багийн Засаг дарга нар шууд хариуцан зохион байгуулж хэрэгжүүлнэ.

1.4. Хязгаарлалтын бүсэд өөрчлөлт орох болон бохирдлын хэмжээнээс хамаарч журамд зохих нэмэлт өөрчлөлт оруулж болно.

1.5. Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно:

1.5.1. "Стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн" гэж Монгол Улсын болон Олон улсын стандарт, норм шаардлагад нийцсэн сайжруулсан зуух, сайжруулсан түлш болон сэргээгдэх эрчим хүч (нар, салхи, газрын гүний дулаан), био түлш (ургамал, амьтны гаралтай тосноос гарган авсан шингэн), цахилгаан бүх төрлийн хийн халаагуурыг;

1.5.2. "Сайжруулсан зуух" гэж "Орон сууцны хатуу түлшээр ажилладаг зуух-Тавигдах шаардлага ба турших аргачлал "MNS EN 13240:2011" болон "Халаалтын ба гэрийн зуухны яндангаар гарах утааны найрлага дахь агаар бохирдуулагч бодисын хүлцэх дээд хэмжээ ба хэмжих арга" MNS 5457-2005 стандартуудыг нэгэн зэрэг хангасан зуухыг;

1.5.3. "Сайжруулсан түлш" гэж Монгол Улсын "Шахмал түлш. Техникийн шаардлага" MNS 5679:2011 стандартын шаардлага хангасан Нүүрсэн шахмал түлш, Хагас коксон шахмал түлш, модны үртсэн шахмал түлшийг;

Хоёр. Агаарын чанарыг сайжруулах бүсэд хэрэгжүүлэх арга хэмжээ

2.1. Агаарын чанарыг сайжруулах бүсэд оршин суугаа болон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

2.1.1. Айл өрхүүдийг олон улсын болон үндэсний стандартын шаардлагыг хангасан цахилгаан болон бүх төрлийн хийн халаагуур, бүрэн шаталттай халаалтын зуухаар үе шаттайгаар хангах ажлыг зохион байгуулж, 2020 он гэхэд энгийн галалгаатай халаалтын зуух хэрэглэхийг бүрэн зогсоох.

2.1.2 Энэ журмын 2.1.1-д заасан арга хэмжээний хүрээнд баталгаажих түвшнээс доогуур орлоготой айл өрхийг цахилгаан болон бүх төрлийн хийн халаагуураар хөнгөлттэй үнээр хангах ажлыг үе шаттайгаар орон нутгийн төсөв, олон улсын байгууллагын тусламжийн хөрөнгөөр зохион байгуулах.

2.1.3 Дулаан алдагдлыг багасгах зориулалттай стандартад нийцсэн нэмэлт дулаалга хэрэглэх;

2.1.4 Халаалтын зуух ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага агаарын бохирдлыг бууруулах тоног төхөөрөмж суурьлуулах

2.1.5 Сайжруулсан түлшний хэрэглээг нэмэгдүүлэх, түүхий нүүрсний хэрэглээг үе шаттай бууруулах

2.1.6 Хөнгөлөлттэй үнээр худалдан авсан сайжруулсан зуух болон бусад бүтээгдэхүүнийг бусдад шилжүүлэхгүй, зарж борлуулахгүй байх;

2.1.7 Агаарын чанарыг сайжруулах бүсэд оршин суугаа айл өрхөд жил бүрийн 10 дугаар сарын 01-ний өдрөөс дараа оны 03 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд өдөр, шөнийн хэрэглээний цахилгаан, эрчим хүчний үнийг эрчим хүчний сайдын тушаал шийдвэрийн дагуу хөнгөлөх

2.1.8 Агаарын чанарыг сайжруулах бүсэд оршин суугаа болон үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж байгаа айл өрх, иргэн, аж ахуй нэгж байгууллагын бүртгэлийг гаргаж мэдээллийн санг хөтлөх;

2.1.9 Агаарын чанарыг сайжруулах бүсэд оршин суугаа болон үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж байгаа айл өрхөд стандартын шаардлага хангасан зуух, цахилгаан халаагуур, аж ахуйн нэгж байгууллагууд стандартын шаардлага хангасан техник тоног төхөөрөмж хэрэглэх;

2.1.10 Аж ахуйн нэгж, байгууллага Засгийн газраас тогтоосон жагсаалтад заасан стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг худалдан авсан бол тухайн бүтээгдэхүүний үнийн дүнтэй тэнцэх орлогыг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18.4-д заасны дагуу татвараас чөлөөлөх;

2.1.11 Агаарын чанарыг сайжруулах бүсэд мод тарих, ногоон байгууламж бий болгох мөн ногоон байгууламжийг ашиглалтын талбай, албан газрынхаа ойролцоо нэмэгдүүлэх тоосжилтыг багасгах;

2.1.12 Агаарын бохирдлын эх үүсвэр, сөрөг үр дагавар, агаарын бохирдлыг бууруулах техник технологи, бүтээгдэхүүний ач холбогдол, ахуйн хэрэглээнд шатдаг хий ашиглах, аюулгүй ажиллагааны талаар сургалт сурталчилгаа явуулах

Гурав. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүлээх үүрэг

3.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь өмчийн хэлбэрээс үл хамааран агаарын бохирдлыг бууруулахад дараахь үүргийг хүлээнэ. Үүнд:

3.1.1. Агаар бохирдуулагч аливаа эх үүсвэр ашиглаж үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхдээ мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулна.

3.1.2. Агаарын чанарын стандартад нийцсэн зуух, хий, цахилгаан халаагуур болон боловсруулсан түлш сонгон хэрэглэх

3.1.3. Гэрийн дулаан алдагдлыг багасгах зориулалттай стандартад нийцсэн нэмэлт дулаалга хэрэглэх

3.1.4. Агаарын бохирдлыг бууруулах хязгаарлалтын бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгж, иргэн бүр орчны ногоон байгууламжаа хамгаалах, арчилж ургуулах хэрэв ногоон байгууламжгүй бол өөрийн эзэмшиж байгаа талбайн арваас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний газарт болон Мандалговь хотын захирагчийн ажлын албанаас тогтоосон талбайд ногоон байгууламжийг заавал бий болгох ажлыг зохион байгуулах;

3.1.5. Төрийн захиргааны төв байгууллага, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага, аймаг, сумын Засаг даргын шийдвэр, улсын байцаагч, багийн Засаг даргын шаардлагыг биелүүлэх;

3.1.6. Агаарын тухай хууль, дүрэм, журам, бохирдуулах бодисын хаягдлын стандарт, хэм хэмжээний шаардлагыг хангах;

3.1.7. Агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага нь стандартын шаардлага хангаагүй тенхик тоног төхөөрөмж ашигласан, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул учруулах нөхцөл байдал бий болсон нь тогтоогдсон үйл ажиллагааг хязгаарлах буюу түр зогсоох;

3.1.8. Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр болон бусад хэлбэрээр сум, багийн иргэдийн нийтийн хурлаас зохион байгуулж байгаа сургалт, сурталчилгааны ажилд идэвхтэй оролцох;

3.1.9. Агаарын чанарт сөргөөр нөлөөлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны талаар эрх бүхий этгээдэд үнэн зөв мэдээлэх;

3.1.10. Байгууллага бүр энэхүү журмыг иргэн, олон нийтэд сурталчилан таниулах;

3.1.11. Түлшний шаталтаас үүссэн үнсийг зориулалтын битүүмжлэл сайтай зориулалтын саванд хийж хадгалж, тээвэрлүүлэх

3.1.12. Агаарыг хамгаалах талаар мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвлөгөө авах;

3.1.13. Түүхий нүүрсний хэрэглээг үе шаттай шийдвэрлэх, сайжруулсан түлшний хэрэглээг нэвтрүүлэх болон агаар бохирдуулах бусад хаягдал зүйлс зориулалтын бус түлш, амьтны сэг, дугуй, нийлэг уут, ашигласан тос, масло, хог хаягдал түлэх, шатаахгүй байх;

3.1.14 Ган-илч, Тэвшийн говь, Дундговь-Ус ХХК-ны уур болон усан халаалтын зууханд холбох боломжтой нам даралтын зуухыг холбох асуудлыг судлах, дулааны станц ашиглалтанд ороход нам даралтын зуухны ашиглалтыг бүрэн зогсоох

3.1.15 Хязгаарлалтын бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа ААНэгжийн хашаанд харуул сахиулын ажилтай айл өрхийг нүүлгэн шилжүүлж, камержуулах ажлыг зохион байгуулах

Дөрөв. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хориглох зүйл

4.1. Мандалговь хотын агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад дараах зүйлийг хориглоно. Үүнд:

4.1.1. Агаарын чанарын стандартыг хангаагүй техник, технологи, тоног төхөөрөмж нэвтрүүлэх, ашиглах

4.1.2. Хог хаягдлыг ил задгай шатаах;

4.1.3. Зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулах

Тав. Хязгаарлалтын бүсэд тавих хяналт

5.1. Энэхүү журмын хэрэгжилтэд Мандалговь хотын захирагчийн ажлын алба, багийн Засаг дарга нар болон эрх бүхий албан тушаалтан /Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мандалговь хотын Захирагчийн ажлын алба/ хяналт тавина.

5.2. Агаарын бохирдлын хэмжилт болон дүгнэлтийг Ус цаг уур, орчны шинжилгээний газрын судалгаа шинжилгээнд үндэслэн гаргана.

5.3. "Агаарын бохирдлыг бууруулах хязгаарлалтын бүс"-ийн айл өрхийн мэдээллийг гаргаж Ус цаг уур, орчны шинжилгээний газрын нэгдсэн мэдээллийн санд оруулна.

Зургаа. Хариуцлага

6.1. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд "Агаарын тухай" хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.2. Сайжруулсан зуух, цахилгаан халаагуур хөнгөлөлттэй үнээр худалдан авсан эзэмшигч нь зуухаа бусдад шилжүүлсэн, худалдсан бол үндсэн үнээр нь төлүүлнэ.

6.3 Энэхүү журмыг дагаж мөрдөөгүй тохиолдолд хуулийн дагуу албадан нүүлгэх хүртэл арга хэмжээ авна.

Долоо. Хүчин төгөлдөх болох

7.1. Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгэгдэж, хууль зүйн мэдээлэл сэтгүүлд хэвлэгдсэн өдрөөс 10 хоногийн дараа мөрдөж эхлэх